

Шүгэл үлээх бодлого

Энэхүү бодлогоор “шүгэл үлээх” /цаашид мэдээлэх гэх/, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Энэхүү бодлогын зорилго нь асуудлыг тогтоох, түүнийг ямар нэг болгоомжлол, айх эмээх зүйлгүйгээр мэдээлэх, цаг хугацаанд нь шийдвэрлэх, мэдээлэл болон мэдээлэл гаргасан ажилтны нууцыг хадгалахад оршино.

Энэхүү бодлогын дагуу дараах үйлдлийн талаар мэдээлнэ. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй үйлдэл;
- Банкны дотоод дүрэм, журам, тушаал, шийдвэр, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн болон дараах үйлдлүүд:
 - Банкны өмч, мөнгө, хөрөнгөтэй холбоотой итгэл алдсан үйлдэл
 - Ашиг сонирхлын зөрчлөө толилуулаагүй үйлдэл;
 - Албан тушаалын эрх мэдлээ ашиглан ажилтанд аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлсэн үйлдэл;
 - Бэлгийн болон сэтгэл санааны дарамт, шахалт үзүүлж буй үйлдэл;
 - Ажил мэргэжил, албан тушаалдаа хайнга хандсан, алдаа гаргасан үйлдэл;
 - Аливаа хууль бус, зүй бус зүйлийг нуун дарагдуулж буй үйлдэл;
 - Бусад эрсдэлтэй гэж үзсэн үйлдэл, эс үйлдэл.

Шүгэл үлээгч нь мэдээллээ Банкны дотоод тусгай зориулалтын мэдээлэх цахим шуудангийн хаягаар эсхүл өөрийн биеэр ирж, банкны Хянан нийцүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргана. Шүгэл үлээгч асуудлын талаар өөрийн хэмжээнд баталгаа, нотолгоо гаргаж өгнө.

Энэхүү бодлогын дагуу үнэнч шударга сэтгэлээс мэдээлэл гаргасан ажилтанг хохирогч болгохгүй талаар мэдээллийг хүлээн авсан болон мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн ажилтнууд анхаарч ажиллана.

Мэдээллийг хүлээн авсан болон мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн ажилтнууд мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээлэл гаргасан ажилтны нууцыг хамгаалах үүрэгтэй.

Мэдээлэлд дурдсан асуудал нь шалгалтаар нотлогдоогүй ч мэдээлэл гаргасан ажилтанд хариуцлага хүлээлгэхгүй.

Мэдээлэл болон мэдээлэл өгсөн ажилтны нууцыг задруулсан ажилтанд банкны Хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулна.